

Геологич болох гэж бэдэрч явахдаа хийсэн тэмдэглэлээс

Ж.Бямба

Өндөр насны оргил өөд мацаж (80 гарч 90 нас дөхөж) яваад эргээд харахад оройтсон ч гэсэн мэргэжил нэгт геологичиддоо хэлчихмээр, магадгүй олон биш ч гэсэн сүүлчийн удаа ч байж магадгүй хааяа оюун санаанд орж гарч явдаг миний амьдралд тохиолдож байсан үйл явдал, түүнээс ургасан сургамж байдгийг хэлье гэж бодлоо.

1. Миний гарал үүсэл. Аав, ээж, ахан дүүсийн ач тус. Мэгд овогтой Жамбын Бямба миний бие дэлхийн үүсэл хөгжил, түүний дотор органик юмсын үүсэл, хувьслын явцад Төв Азийн төвдөнө эртний түүхт монгол үндэстнээс бүрдсэн тус улсад 1941 онд байгуулагдсан Баянхонгор аймгийн Богд сумын нутагт хавар болж ханш нээгдэн үндэстэй болгон ургаж, үртэй болгон төллөж байхад баринтгаа тайлж байсан Орог нуурын урд талыг эмжилсэн харьцангуй өргөн, зүлэг голдуу ургамалтай, цагийн сайханд бол өнгийн цэцэг солигдсон цэцгэн хээтэй хивс лугаа адил харагддаг ширгийг урд талаас нь хүрээлсэн Говь-Алтайн уулсын бэлтэй уулзах заагийг дагаж ургасан дэрс, хармаг, бударгана бүхий нарийн зурвас хаяагийн дулаахан өвөлжөө бууцыг дагаад нутгийнхан идэр гурван ес, цагаан сарын баяраа өнгөрөөгөөд хавар болоход малаа төллүүлнэ. Зун болохоор ялаа, шумуулаас зугатан нүүж дөрвөн Богдын ууландаа (хярдаа) гарч зусна. Тэр жил 1940 оны хавар энэ л Чулуут, Хоёр сайрын хоорондох нутагт “ногоо” хочит Самбуугийн хүүхдүүд болох С.Дашдондог, С.Жамба хоёрынх айлан хаваржиж байсан бололтой.

Хавар болж луу жил гарч байхад эцэг Ц.Рэнцэндорж, эх Д.Чимэд хоёрын болзоо, боломж тохиож, тэр хоёрын эсвэл бурхны ивээлээр “зүүний үзүүр дээр арвайн үр тогтож” энэхүү миний биеийн үүсэл анх олдож байсан нь цаг хугацаа, орон зайн хувьд илүү магадлалтай билээ.

Олон удаагийн газар хөдлөлөөр гүний хагарлын бүсийн дагуу эрүүл газаргүй болтлоо хумхигдаж бутран сархинаг шиг болсон тэр Шавьнах, Шанага, Хангинахын дов, Хажуу, Жаал шанд, Өвтийн дов, Улиастай гээд булаг шанд урссан энэ нутагт Мушгайн Ширээ хэмээх огт эвдрээгүй үлдсэн нэгэн тэгшхэн нутагт би гэдэг, хүн болон бүрэлдчихээд байхад эх минь урвасан ах С.Дашдондогийндоо намрын дунд сарын шинийн гурванд, үүр шөнийн завсраар ургах нартай уралдан бүдүүн дуугаар хорвоод ирснээ зарласнаар мэндэлсэн түүхтэй.

Ингээд намайгаа (ууган хүүгээ) айлынхаа ханилаад удаагүй үрийн мөрөөдөл болсон өөрийн дүү Жамба, түүний эхнэр (өөрийн эхнэр Даваажидын дүү) Жавзанпагма хоёртоо төрөөд ангир уургаа долоо хоног ч хөхөөгүй байхад өдрийн сайныг сонгон байж бямба гарагт хадаг юугаа өргөсөн авга ахын гарт өргөн барихдаа эхийн минь сэтгэлд харамсах сэтгэл өчүүхэн ч гэсэн төрөө болов уу яагаа бол. Үрчилсэн аав Жамба, ээж Жавзанпагамын асрамжаар би гэдэг хүн “эр өсөж, эсгийн сунадгийн” жамаар аажим аажмаар өсөж өндийн Богд сумын бага, Өлзийт сумын дунд, аймгийн төвийн Галуутын бүрэн дунд сургуулиудыг дамжин тэр үеийн

нам, засгийн мэргэн бодлогоор тэр үедээ “алтан” хэмээх тодотголтой Москвад газар дэлхийгээ судалдаг геологич гэдэг мэргэжил эзэмшихээр үе тэнгийн аавын олон охид, хөвгүүдийн хамт галт тэргэнд суугаад хөдөлж байсан билээ. Тэгэхэд намайгаа нэг ангийн Ц.Маам, Б.Дагдан, Н.Жинсуйз, хамаатан “ногоо” Самбуугийнхны Должингийн Бямбаа, Пагмын Бямбаа, Дашдондогийн Янжмаа болон тэр жил мал туугаад хотод амжиж ирсэн байсан хойд эцэг С.Чимэд нар 1959 оны 8 дугаар сарын сүүлчээр үдэлцгээж билээ. Тэр өдөр цэлмэг тэнгэрийн нар орой дээрээс гийгүүлж, хаанаас гараад ирэв гэмээр борооны ганц нэг дусал хаялж, вагоны чанга яригчаар үдэж байгаа ба эрдэм сурахаар үдүүлж байгаа хүмүүст зориулсан дууны ая сонсогдсон яасан сайхан өдөр байгаа вэ!

2. Геологич болох замд оров. Энэ Москва хүрэх 6000 гаруй урт төмөр замаар Өвөр Байгаль, Сибирь, Уралын нуруу, Дорнод Европыг нэвт туулаад Москвагийн Геологичайгуулын дээд сургуульд суралцахаар очиж байсан юм даг. Эхлээд тоо, орос хэлний мэдлэгээ шалгуулан дульхан мэдлэгтэйгээ ойлгоцгоож билээ. Бидний Ч.Дашням, Д.Баяр, Л.Лхагва, Р.Сампил, Л.Долгормаа, М.Дамбажамц, Я.Гомбосүрэн, Я.Болд нарын хэдэн хүүхдүүд геологич болж элс, хайрганаас эхлээд эх дэлхийгээ бүтнээр танин мэдэх эрдэмд “А”-гаас нь эхлээд суралцаж эхэлсэн юм. Энэ үе бол миний амьдралын хамгийн галтай цогтой, цовоо сэргэлэн, гэнэн тэнэг явсан залуу үе минь байлаа. Энэ сайхан насаа одоо эргээд амьдралын ухаан суусан хойно санахад хайран цагаа даанч дэмий өнгөрөөсөн байж дээ. Юу хийх ёстой байгаа гэвэл орос хэлнээс гадна япон, англи, хятад, герман хэлнүүдийн аль нэг дугуйланд явж ганц ч гэсэн хэлтэй болох, судлах зүйл нэгтэй физик, хими гэх мэтийн шинжлэх ухаан курс дугуйлангийн

болон бусад хэлбэрээр зэрэгцэн суралцах боломжтой байжээ. Хайран цаг. Чи юу хийж чөлөөт цагаа өнгөрөөсөн бэ? Дээд сургуулиудыг хэсэж охидуудыг дугаарлуулан ча-ча, рок-н-ролл, твист, вальс зэрэг бүжгүүдийг хийх, бас тэмцээнд нь орж дээгүүр байр эзлэхээс гадна Москвагийн Измайловын, Филийн, Горькийн ба Сокольникийн зэрэг зугаалгын газруудаар явж цана, тэшүүрээр гулгах, зоогийн газар, ресторан хэсэх зэргээр ихэнх цагаа өнгөрөөжээ.

Амьдралдаа хэзээ ч мартаггүй нэгэн ололт бол ширээний ард микроскоп харж юм уу эсвэл сурах бичиг уншаад эсвэл график, зураг зураад үнэн худлаа нь мэдэгдэхгүй цээжилж байсан онолын мэдлэг маань амьдрал дээр оюутны хээрийн дадлагын явцад батлагдаж байсан нь сонирхолтой бас гайхалтай сонин байлаа. Ялангуяа метасоматоз бүсийн метаморфизм, пегматит өргөн хөгжсөн Алданы бамбайн жишээн дээр тэр эрдсийн эвшил, бүтэц, байрлал, өнгө, цуурал зэрэг физик, химийн шинжүүд энгийн нүдээр илүү тодоор харагдаж байлаа. Гэхдээ энэ бүгдийг хөлөөрөө явж, биеэрээ мөлхөж, өлсөж, цангаж, ядарч зүтгэж байж олж авсан даа.

3. Геологич болох гэж бэдэрч явсан зам.

Геологийн мэргэжил эзэмших гэж байгаа оюутнууд суралцах хугацаандаа 2 удаа үйлдвэрийн дадлагад явдаг байлаа. Би энэ дадлагаа ёстой хүний мөр цөөхөн хүрсэн нутагт явж хийе гэж бодоод алс холын Якут нутагт хийсэн юм. Энэ явцад над шиг шинэхэн оюутанд тохиолдож байсан үйл явдлаас зарим нэгийг доор дурдав. Үүнд:

- Хөл гишгэх газаргүй хөлгүй, гүнзгий 1-2 км өргөн Алдан мөрний урсгалын эрхээр хаа хүрээд хаана зогсохыг мэдэхгүй зүүгдэж яваад азаар голын налуу эрэг рүү газардаж, нэг юм амь аврагдаж, хамаг хоол хүнсээ ачсан завиа аварч билээ.

- Маршрутад явж байгаад үдийн цайгаа уучаад эргээд хартал хатаах гээд бутан дээр тавьсан хөлийн минь ороолтыг зуугаад хойд хоёр хөл дээрээ зогсож байгаа баавгайтай бие бие рүүгээ хараад нүүр тулан зогсож байгаад мэнд мэдэлцсэн ч юмгүй ашгүй нэг юм мөр мөрөө хөөгөөд үг дуугүй хоёр тийшээ салж билээ.
- Тэр өдөр манай талбай дээр хийх ёстой нэгэн маршрутын замд тектоникийн хагарлын дагуу үүссэн Юс-Кюэль гэдэг нуурын хажуугаар явах болсон юм даа. Тэр хажуугаар ёстой л элгээрээ мөлхөж байж гарсан даа. Доошоо харахад хөлнөөс мултраад унаж байгаа чулуу эргэлдсэн ногоон ус руу цүлхийгээд унана, дээш харахад одоохон унах вий дээ гэж болгоомжилмоор хад чулуунууд өнгийнө. Аажим мөлхөхөд өргөстэй ч гэсэн овоо бөх үндэстэй ургасан бутнуудаас татаж чангааж байж гарч байлаа. 1-1,5 км хиртэй үргэлжилсэн зам бартаагаа арай гэж туулаад буцахдаа нуурын нөгөө хажуугаар явахад арай хялбар байлаа. Юс-Кюэлийн дүүрэгт маршрут хийж дуусаад эргэж ирээд бага зэрэг хоол хүнсээ авах гэтэл модны орой дээр ачаагаа байрлуулсныг баавгай нураан лаазтай молоко, нөөшилсөн махыг хага хага базан онгойлгоод дуусгасан байв. Бид ч энд хонож болохгүй гэдгээ ойлгож шууд голоо уруудсаар нэгэн халцгай газар хоноод маргааш өглөө нь босоод бусад нөхөд рүүгээ явж байтал бидний хоносон газраас бололтой утаа олгойдоод түймэр гарчээ. Бид унтраахаар очиж жаал цохьсон боловч орой дээрээс шатсан мөчир унаад, хөл дороос зүлгэн доогуур шатсан хөвд түлчих гээд арай гэж нэг юм зугатаж гол гаран амьд мэнд гарч билээ.
- Төвийн амьдралыг алсын Якуттай холбож байсан Амар-Якутын (АЯМ) замаар

дүүрэн хөлдүү мах ачсан ачааны урт машинд гар өргөн дайгдсаар лагераасаа 19 км зайтай буугаад алхах болов. Зам цасаар битүү хучигдсанаас гадна цас нэмээд орж байв. Энд замд юу юу тааралдаж байсан гээч. Эзгүй хээр харанхуйд мэдэхгүй газар, хүний нутагт шөнө орой болсон хойно цас унаж зам бүдгэрч байлаа. Мэдэхгүй замаар ерөнхийдөө айдастай тайга дундуур явахад эргэн тойрон гал шиг хос нүднүүд асаж унтран нэг ойртож, нэг холдоно. Янз бүрийн дуу гарна. Замд гол дээгүүр тавьсан гүүр эвдэрсэн тул би эвдэрхий гүүрээ тойроод хөлдсөн голын дээгүүр гарч явтал халтираад унахдаа, халааснаасаа гараа сугалахдаа атгаж байсан нэг хайрцаг чүдэнз, сахлын хутга, лаазтай мах зэргээ гаргаад цацан үнхэлцгээ хагартал айн арай гэж нэг юм цуглуулж аваад гал асаах гэсэн боловч салхитай хүйтэнд гал асааж чаддаггүй юм билээ. Нөгөө лаазтай махаа ч онгойлгох аргагүй болж би гэдэг айдаст автсан хүн улам айх сандрах нэмэгдсээр цааш алхав. Цас орсоор муухан харагдаж байсан мөр ч харагдахгүй болжээ. Ганц модны хажууд шуудайтай талх, тэсэлгээний материал байв. Манай ажилчид явсан бололтой. Талхаа гаргаж идэх гэсэн боловч тас хөджээ. Хүйтэнд шээс их хүрнэ. Өмднийхөө товчийг тайлаад буцаагаад товчилж чадахгүй, хуруунууд бараг хөджээ. Мэдээгүй болжээ. Толгойн тал минь бүлээн амьсгаанд бага зэрэг дулаацаж эргэж хараад хэвтэнэ. Ингэж эргэлдсээр байж үүр цайхад уулын ерөнхий байдлаар баримжаагаа олж мөлхсөөр нэг юм майхандаа арай гэж очиход манай майхныхан сандарцгаан намайг гэсгээхдээ галд ойртуулалгүй гадаа спирт, цас мөсөөр хөл, гар, толгой нүүрийг үрж арчин гэсгээж аажим аажмаар галд дөхүүлэн майхны үүдэнд ойртуулсаар үнэхээр хөлдсөн газаргүй амь насыг минь аварсан билээ.

Энд би ураны илрэл дээр тэсэлж малтсан шуудуунуудыг цэвэрлэн бичлэг хийдэг байлаа.

- Өөр нэг адал явдал. Бид хоёр маршрутаас буугаад иртэл манай хөсөг маань нүүгээд гарахын аргагүй өргөн голын нөгөө эрэгт буужээ. Тэндээ хонохоос өөр аргагүй болж, маргааш ангиас завь авчрах болов. Хоноход хуурай газар байхгүй болохоор эхлээд усанд автаагүй хайрган дээрээ гал түлж халаагаад зөөлөн мөчрүүд хугалж дэвсээд түүн дээрээ нэг талаараа хэвтэхэд дороос халуун уур цоргиод, нөгөө талаараа эргээд хэвтэхэд дээд талын халсан хэсэг маань хөрөөд даарч эхэлнэ. Ингээд техникч бид хоёр унтах аргагүй болохоор нь босон мөчиргүй болсон томхон модоор нь сал хийв. Нөгөө голоо гарахаар шийдэн хөвсөөр холгүй байсан харгиан дээр нааш ч үгүй, цааш ч үгүй гацав. Бууж болдоггүй, явдаггүй, тэндээ хөлдөх шахаж өглөө болгон завь ирэхээр нэг юм гарч билээ. Бас л хүйтэн байсан даа. Ер нь иймэрхүү жижиг адал явдал байнга тааралдана. Ялангуяа олон хоногийн маршрутад бараг үргэлж бий болно.
- Маршрутад явж байхдаа шөнө унтахдаа мөчрөөр толгойгоо халхлах төдий шалаш (овоохой) босгоод үүдэндээ баавгайнаас хамгаалах гэж том мод асаагаад дан даавуун уутанд унтана.
- Бас нэг гурван хоногийн маршрутад явах болж бидний геологичид хоёр салан өгсөж явсан голынхоо хоёр талаар маршрутаар яван голынхоо эхэнд уулзахаар тохиролцов. Эхний өдрөөс эхлээд бартаатай тулав. Замд ширүүн бороо орж нэгэн ширэнгэн дундуур гарахаас өөр аргагүй болов. Зам бүдгэрч цаа буган хөсөг маань явах аргагүй болсон тул шинээр пальма хэмээх якут том хутгаар замд байгаа модоо цавчсаар 2

км газар зам гарган нөгөө талд гартал нэг цааны амнаас хөөс сахран салгалж цээжнээс нь цус олгойдоод цааш явах боломжгүй болоход хөсөг авч яваа эвенкүүд шинэ шөл уух юм болж тэр дор нь янзлаад цааш явав. Цааш сайхан тод замаар явж байтал зам маань бараг 75 градусын огцом налуу том том чулуун дундуур оров. Бид ачаатай цаануудаа зөнгөөр нь нэг нэгээр нь туучхав. Цаанууд бүгд буусан боловч нэгнийх нь хөл хадны завсар хөшигдөөд хугарчээ. Бас шинэ махны нөөцөө нэмэхээс өөр аргагүй болов. Бид тэндээ хонох болж нөөшилсөн ногоотой, 1 см хиртэй том “амиа хорлосон” шумуулуудын хачиртай шөлөө “ангийн юм гэж час хийж байна” гэж инээлдээд идэцгээв. Тэгээд л маргааш орой нь нөгөө болзсон газраа очихоор явж байтал голын элсэн дээр нэгэн саяхан явсан бололтой баавгайн шинэхэн мөр дайралдахад дагаж явсан хоёр нохойны хар нь гаслаад гэдрэгээ хараад ойчив. Харин цагаан нь нөгөө мөрний хойноос хуцаад битүү ширэнгэн ой руу ороод алга болчхов. Би гэж нэг хаанаас баавгай гараад ирэх бол хэмээн айсан юм цагаан нохой орсон зам руу шувууны буугаар 2-3 буудчихаад явж орлоо. Юм л тааралдсангүй. Голын эхэнд болзсон голын эх маань туулахад хүндрэлтэй болжээ. Хайлсан мөс олон салаа 1 м хүртэл гүнтэй жижиг голууд (горхинууд) болж хувирсан байв. Бид нар гал түлж, буу буудалцаж, дохио өгсөөр кирзен гутлаараа ус хутгасаар “усан хулгана” гэдэг шиг шал нойтон юмнууд хоёр талаасаа уулзацгааж билээ.

- Бас нэг маршрутад явж байхад замын хажууд нэгэн хайсаар хамгаалсан шарил байсан нь хамт явсан техникчийн ярьснаар энэ бол тэнд эрэл хийж байсан нэгэн геологичийн оршуулга гэнэ. Хувьсгалын эхний үед нутгийн мэргэн буучид газар

орноо, баялагаа хамгаалан ганц нэгээрээ явж байгаа геологичдыг ингэж хороодог байжээ. Аюултай байсан байгаа биз. Энэ геологичийн үйлийг би үргэлжлүүлж яваа гэж бодохоор хаанаас буудуулах бол гэсэн бодол төрж эргэн тойрноо харж билээ. Одоо бодоход энэ адал явдлууд бол зүгээр нэг өдөр тутмын амьдрал байсан. Түр зуурын богинохон хугацаанд болоод өнгөрнө. Тухайн үедээ залуу нас, эрүүл биеэр даван туулж байжээ. Тэр жилүүд дандаа тийм байгаагүй. Бас сайхан мөчүүд байсан. Алсын бараа хараад сахартай хар цайгаа уугаад сууж амрах. Хээрийн ангидаа ирээд майханд хийсэн халуун саунд суух. Маршрутад хааяа тааралддаг пегматитийн биетийн эрдсийн эвшлийг ажиглан шпинель, кальцит, флогопит, сподумен, хээрийн жоншны талстын бичлэг хийн сонирхох. Одоо бодоход Становын нурууны нэгэн оргил дээр гараад алсад зах нь харагдахгүй их усыг (бодвол Номхон далайг) ажиглан эх дэлхийнхээ тухай эргэцүүлэн мөрөөдөх. Ингэж ТУКЭ (Тимптон» Учурин) ба ЮЯКЭ Өмнөд Якутын комплекс экспедицүүдэд 2 жил дадлага хийж явахдаа бичиж байсан тэмдэглэлээсээ товчхон дурдахадийм байна.

4. Сургамж

- Хөдөө хээр мэдэхгүй газар маршрутад заавал хоёулаа явж байх.
- Хоёулаа ч гэсэн өмнө нь хүн явж байгаагүй газраар явахдаа биеэ хамгаалах буу, дохионы ракеттай явж байх.
- Геологич болох гэж байгаа бол та заавал урсгал усанд (голд) сэлж, морь унаж сурсан байх.
- Ялангуяа олон хоногийн маршрутад явж байгаа бол замын бартаа (гол, ус, даваа гүвээ, хад чулуу) замд хоноглох газруудаа сайн сонгон товлож мэдсэн байх.
- Маршрутад явж байхдаа зэрлэг араатантай дайралдвал түрүүлж түүний эсрэг хөдөлгөөн, үйлдэл хийхгүй байх.
- Хамт явж байгаа техникчээ (туслахаа) үзэл бодол (санаа) нийлсэн хүнийг сонгох.
- Олон хоногийн маршрутад явж байгаа хонохдоо гал, усны аюулгүй газар сонгож байх.

5. Мөрөөдөл биелэв. Сайн муу нөхөд.

Би чинь дунд сургуульд суралцаж байхдаа “Алтайд” романы гол баатар геологич Панов, Баяр нарын дүрд хөтлөгдсөөр мэргэжлээ сонгосон юм шүү дээ. Тэр мэргэжил маань сайхан мэргэжил байсан. Түүнийг эзэмших зам бартаатай, хожим эргээд санахад амьдралд хат суулгасан байжээ. Сүхээ дэрлэж, цэнэгтэй буугаа дэргэдээ тавиад унтдаг, Сибирьт цөлөгдөж байгаад тэндээ үлдсэн хүмүүстэй 2 жилийн дадлагын явцад нөхөрлөж, зэрэгцэн унтаж явлаа. Хамт ажиллаж байсан нөхөдтэй захидлаар холбоотой байхад надтай хамт явдаг байсан цөллөгөөс сулагдсан нэг нь “тэр монголыг (намайг) буудах байсан юм” гэж хэлж байсан тухай нэг удаа бичиж билээ. Якутын манай ангийн геологичид надад бараг сар, улирал болгонд 50-100 рубль шуудангаар гуйвуулна. Сайн ажиллаж байсны шагнал юм даа. Залуу насандаа амьдралын тийм бартаат замаар бэдэрч явсан маань намайг аливаа юманд тэвчээртэй, сайн ханна сонгох, сайхан үр хүүхэдтэй болоход бага ч гэсэн тус болсон гэж боддог доо. Намайг мэддэг таньдаг байсан хүний, өөрийн бүх хүмүүст их баярлаж явдгаа илэрхийлье.

6. Эрүүл явж ихийг бүтээхэд засгийн зөв бодлого, амьдралын түшиг юу юунаас илүү хэрэгтэй байв. Тэр даарч хөрж, мөсөн голын хүйтэн усанд цасан дунд удаан хугацаагаар бээрч, осгох алдан явсан, шөнөжингөө их устай голын харгиан дунд даарч байсан зэрэг бол

яваандаа намайг байнгын даралттай, бөөрний дутагдалтай болгосон нь намайг залуугаараа аливаа өвчинд өртөмтгий болгосон.

- Намайг байнгын даралттай, туршлагагүйгээсээ болоод цус их алдаж байсан ба хануулж явснаас болоод үхэн үхтлээ цусаа нөхөх аргагүй болгосон. Эрэгтэй хүний цус хэзээ ч нөхөгддөггүйг эрчүүд санаж явахад илүүдэхгүй. Тэгээд чи яагаад одоо болтол өндөр наслаад (85 хүртэл) явж байна вэ. Тэгвэл доорх хэдэн хүчин зүйл байсан гэж боддог.
- Аливаа өвчин тусахад тэр даруйд нь эмнэлэгт хандаж илааршуулж байсан. Тухайлбал нэг бөөрөө солиулсан, нэг бөөрөө бүрмөсөн авахуулсан.
- Залуудаа бараг өглөө болгон Зайсан толгойг тойроод юмуу Баянзүрхийн гүүр хүртэл гүйнэ.
- Бараг долоо хоногт нэг удаа, эсвэл төрөөс цагаан сарыг тэмдэглүүлдэггүй байсан болохоор нөхдийн хамт Богд уулыг даваад Төв аймаг хүрдэг алхдаг байсан. Заримдаа хонуутаар явна.
- Намайг урт наслахад гарцаагүй нөлөөлсөн хүчин зүйл бол архи уудаггүй. Ямар нэгэн баяраар сайн бол бага багаар амссаар нэг хундагыг л ууна.
- Тамхийг бол нэг ч сорж байгаагүй.
- За тэгээд 60 гаруй жил миний хань (Ж.Дэнсмаа) намайг зөв хооллож, ундааж байсан нь гол хүчин зүйлийн нэг байжээ.

Урт наслахад нөлөөлж болохоор өөр нэгэн хүчин зүйл бол намаас үзүүлж байсан сэтгэл санааны дарамтын эсрэг тэмцэж явлаа. Намайг 2 удаа 2-3 сараар ажлаас халж дарамталж байсан.

1. Олон улсын геологийн экспедиц (ОУГЭ)-ийг миний бие санаачлан СЭВ-ийн орнуудын буцалтгүй тусламжаар 70 орчим

сая ам.долларын хөрөнгөөр байгуулаад 5 жил амжилттай ажиллаж байхад гэнэт халаад хэдэн сар ажилгүй явуулсан.

2. Монголд (аливаа улсад) байх ёстой Монголын Геологийн Албыг хөөцөлдөж байж байгуулаад 3 жил ажил жигдрээд байхад нь зарим нэг үл бүтэх танил талын хүмүүсийн ховоор намайг Япон явж туршлага судлаад ирж байхад эзгүй хойгуур ажлаас халж МГА-ыг татан буулгаж бас хэдэн сар ажилгүй болгосон.

Эцсийн эцэст үнэн ач буянаа өгч ялдаг болохоор ОУГЭ-ийн хөрөнгөөр Өндөр цагаан, Хөлийн холбоо, Баянмөнх овоо, Цагаан чулуут, Мөнгөн өндөр зэрэг вольфрам, мөнгө, алт, титан-магнетитийн ордууд нээгдэн зарим нь ашиглагдсанаас гадна олон хайлуур жонш, зэсийн илрэлүүдэд үнэлгээ өгөгдсөн болно. Мөн иж бүрэн үлгэр жишээ ангиуд байгуулагдан ажиллаж байснаас гадна 144 айлын орон сууц, лабораторийн иж бүрэн бааз бүхий ажлын газар баригдсан. Түүнээс гадна одоо нөгөө намайг халах гэж татан буулгаж байсан Монголын үндэсний геологийн алба дахин шинээр зохион байгуулагдлаа. Ийм л ухаан муутай, алсын хараагүй хүмүүс улсын хөгжлийг хойш нь татаж байсан нь, бүхэл бүтэн салбарын хөгжилд саад болж байсан нь одоо ч мэдэгдэж байна.